

Сайн байна у,

УБЦТС/20240202207 дугаартай "ХАБЭА-н тусгай зориулалтын хэрэгсэл" нийлүүлэх харьцуулалтын тендерийн баримт бичиг ирүүлсэн тодруулгын дагуу нийт оролцогчдод дараах хариуг хүргүүлж байна.

Д/д	Оролцогчоос ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	УБЦТС/20240202207 дугаартай "ХАБЭА-н тусгай зориулалтын хэрэгсэл" нийлүүлэх тендерийн баримт бичгийн Өгөгдлийн хүснэгтэд "Барааны үнийн задаргаа"-г Маягт 6-аар, Үнийн санал-ыг Маягт 1-ээр ирүүлэх гэсэн шаардлагад тодруулга өгнө үү ?	“Цахимд байршуулсан тендерийн баримт бичгийн Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 21.1-д үнийн саналыг Маягт 1-ийн дагуу, Барааны үнийн задаргааг Маягт 6-ийн дагуу ирүүлнэ” гэх шаардлага зөв байна.
2	Шинэчлэн найруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу өөрчлөгдсөн тендерийн баримт бичгийн дагуу баталж гаргасан Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичигт "Барааны үнийн задаргаа" гэсэн маягт байхгүй байгаа ба Маягт 1-ээр "Тендер илгээх маягт"-д "...үнийн санал дуудах ажиллагаанд 3 эцсийн санал болгосон үнээр" гэсэн байдаг.	Жишиг баримт бичгийн 3-р хуудаст Санамж: “ <i>Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт (ӨХ)-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн бэлтгэнэ.</i> ” гэж заасан тул Маягт 6 хүснэгтийг нэмж оруулсан. Маягт 1-ээр "Тендер илгээх маягт"-д ... үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр" гэж заасны дагуу нийт үнийн саналыг ирүүлнэ.
4	УБЦТС/20240202207 дугаартай "ХАБЭА-н тусгай зориулалтын хэрэгсэл" нийлүүлэх тендерийн баримт бичгийн Өгөгдлийн хүснэгт-д заасан шаардлагын дагуу тендер ирүүлэх ёстой юу аль эсвэл шинэ жишиг бичиг баримтын дагуу ирүүлэх ёстой юу?	Санамж: “ <i>Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт (ӨХ)-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн бэлтгэнэ.</i> ” гэж заасан тул өгөгдлийн хүснэгтийн дагуу тендерийн баримт бичгийг ирүүлэх ёстой.

5	<p>Үнийн санал дуудах ажиллагаа явагдахгүй гэж ойлгож болох уу</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн</p> <p>34-р зүйл Харьцуулалтын арга</p> <p><i>“34.1.Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно.”</i> гэж заасны дагуу захиалагч нь үнийн санал дуудах аргыг хэрэглэх эсэхийг өөрөө шийдэх ба үнийн санал дуудах арга ашиглах бол мөн хуулийн</p> <p><i>“34.3.Захиалагч энэ хуульд заасан цахим системд бүртгэлтэй аж ахуй эрхлэгчдэд үнийн санал дуудах урилга хүргүүлнэ.”</i> гэж хуульчилсан тул тухайн тендерт үнийн санал дуудахгүй болохыг нийт оролцогчдод мэдэгдэж байна.</p>
---	--	--

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД АМЖИЛТ ХҮСЬЕ.